

Монгол улс Солонгост 30 биш 330 мянган га газар зарсан

Анх 2011 оны 3 сард Өмнөд Солонгост 99 жилээр газар нутгаасаа түрээслүүлэх болсон тухай Х. Мөнх гэдэг сэтгүүлч бичсэнийг уншсан юм. Тэр нийтлэлд “Монгол Улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Дорнод аймагт очиж ажиллах үеэр БНСУ-ын Засгийн газар, KOICA байгууллага болон Монгол Улсын Засгийн газраас мэдэгдэл хийж Дорнод аймгийн Халх голын сав нутагт тариалан хөгжүүлэх зорилгоор солонгосчуудад 270.000 га газар ашиглуулахаар шийдвэрлэснийг зарлалаа” гэж байсан. Нийтлэлийн төгсгөлд үйл явдал хэрхэн өрнөхийг анхаарахыг олон нийтэд захиад, аливаа гэрээг бас цуцалж болдог тухай сануулсан байж билээ. <http://sonin.mn/?p=119884>

Саяхнаас энэ талаар дахин бичих болсон тул сонирхож, Солонгосын сонин хэвлэлээс нягталж үзлээ. Гэтэл Монголоос **270.000 га биш 330.000 га газар, бас түрээсэлсэн биш худалдаж авсан** тухай бичсэн байх юм.

Тухайлбал, 2011 оны 3 сарын 11-ний “Korea IT Times” сонинд “Солонгос хөдөө аж ахуйн салбар дахь хамтын ажиллагаагаа эхлүүлэхээр Монголд **30,000 (гучин мянга) га газар худалдаж авлаа**” гэдэг гарчигтай мэдээ гарсан байна. Дэлгэрэнгүй мэдээнд Монголоос 816 мянга 880 акр газар худалдан авч Кори буюу Солонгосын эртний Корё хаадын удмын нэрээр нэрлэсэн тариалангийн талбайтай болсноор Солонгосчууд гадаад улсаас хүнсний хараат байдлаасаа ангижирна гээд Дорнод аймгийн засаг даргын орлогч Дамдинбазар, Солонгосын талын төлөөлөгч Ким Хак Су нарын зургийг тавьжээ.

<http://www.koreaitimes.com/story/13469/korea-purchases-30000-hectares-mongolia-initiate-agricultural-cooperation>



Уншигч та газрын хэмжээг андуурсан байна гэж намайг буруутгахаа түр азна. Өмнө нь Монгол сониноос **270.000 га** газар түрээслэх тухай уншсан болохоор чухам ямар учраас газрын хэмжээ **30 мянга болтлоо буурсны** учрыг тайлахыг би оролдлоо. Эхлээд Монголчууд бидний хэрэглэж заншаагүй нэгж болох акр гэгчийг га болгон хувиргаж үзэхэд **816,880 акр = 330 мянга 579 га** болж байв (манайхан бутархай тоонд, харин гадныхан мянгын дараа таслал тавьдаг учиртайг энд анзаарна уу). Тооцохдоо интернэт дээрх хөрвүүлэгч программыг ашигласан юм. Та нар ч гэсэн бас нягтлаарай. <http://www.convertunits.com/from/acre/to/hectare>

Мөн “Korea IT Times” сонины 2011 оны 3 сарын 10-ны дугаарт Монголоос **нэг тэрбум пянг** (Солонгочуудын хэмждэг нэгж, 1 пянг (pyeong)=3.3.ам. метр) хэмжээтэй газар худалдаж авснаа тэмдэглэж баяр хийсэн тухай мэдээ олдлоо. Дурьдсан **1 тэрбум пянг** дахин га- д хөрвүүлж шалгахад **330 мянга 600 га** гарч байна. <http://www.koreaitimes.com/story/13439/special-performance-korea-mongolia-adpi>

<http://www.convertunits.com/from/1000000000+pyong/to/hectares>

Түүнчлэн, *Future Directions International* хэмээх Австралийн бодлого судлал, дүн шинжилгээний байгууллагаас гаргадаг долоо хоног тутмын мэдээ, Хонкогт төвтэй Азийн бүсийн “Asia Sentinel” сонин, “Corn & Soybean Digest” гэдэг Америкийн хөдөө аж ахуйн сэтгүүл зэрэг олон эх сурвалжид Өмнөд Солонгосчууд Монголоос **325 мянга 999 га гаруй** (800 мянга гаруй акр) газар худалдаж авчээ гэсэн мэдээ гарсныг олж баталгаажууллаа.

<http://futuredirections.org.au/publications/14-strategic-weekly-analysis/48-strategic-weekly-analysis-18-5-2011.html>

http://www.asiasentinel.com/index.php?option=com_content&task=view&id=3159&Itemid=234

<http://cornandsoybeandigest.com/issues/foreigners-gobble-land-some-claim-it-s-food-security-some-say-it-s-land-grab?page=1>

Чухам ямар учраас 330 мянгыг 30 мянга болгож нэг тэг алдаж бичсэнийг уншигч бүр дор бүрнээ болгооно биз. Ямартаа ч, Монголчуудын хувьд пянг, акр гэдэг нь ойлгомжгүй байдаг шиг Солонгосчууд га (гектар) гэдгийг мэддэггүй болохоор Солонгос сонинд ийнхүү алдаж бичсэн нь **Монголчуудыг төөрөгдүүлэх гэсэн оролдлого байсан уу** гэсэн хар төрөх юм.

Ингэхэд ер нь 330 мянга 600 га газар гэдэг хэр том юм бэ? Тооцож үзвэл 3306 хавтгай дөрвөлжин км гэдэг нь Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын нутагтай дөхөж очиж байна. Монголчууд бид бүхэл бүтэн сумын дайтай нутгаа гадныханд худалдчихаад “**200 -хан га газарт жишиг сангийн аж ахуй байгуулна**” гээд мэдэн будилж суух гэж үү? <http://mongolnews.mn/i/19485>

Харийнханд худалдсан Монгол нутаг



Газар ямар үнэтэй вэ?

Газрын худалдаа ярихаар хүмүүс газар чухам ямар үнэ ханштай байдгийг сонирхож болох юм. Солонгосчууд мэдээндээ Монголоос газрыг ямар үнээр худалдаж авснаа бичсэнгүй. Тиймээс газрын үнэ ханшийг бяцхан судалснаа та бүхэнд толилуулья.

Баримт 1: . Солонгосчууд аль эрт **1978 онд Аргентины** нийслэлээс 1000 км зайд орших **20 мянга 894 га тал газрыг тухайн үед 2 сая 115 мянган ам. доллараар худалдаж авсан** тухай баримт олж үзлээ. Тус газрыг Парк Чунг-Хий эрх барьж байх үед Гадаад Хэрэг, Худалдааны Яамны харьяа Солонгосын Олон Улсын Хөгжлийн корпорац (шинэ нэр нь KOICA буюу Солонгосын Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг) худалдаж авсан байна. Тухайн үедээ дэлхийн бөмбөрцгийн нөгөө талд байрлах Аргентин руу 300 тариаланч явуулж Солонгос тосгон маягийн юм байгуулна гэж төлөвлөж байсан ч амжилтад хүрсэнгүй. Худалдаж авсны дараахан л цагаачдын эхний хэсэг очиж шар будаа, хөвөн, шош зэргийг тариалаад ургац авч чадаагүй байна. Учир нь тэр газар зундаа 40 гарч

халдаг, өвөлдөө маш хүйтэн, хур тунадас ихтэйгээс гадна хөрс нь хужиртай тул газар тариаланд тохирохгүй байсан гэдэг. <http://farmlandgrab.org/post/view/2506>

Эндээс үзвэл, тухайн үед **1 га газрыг 101 ам. доллараар** худалдан авсан ажээ.

Баримт 2: 2009 оны 11 сарын 19-ний Солонгосын өдөр тутмын “*JoongAng Daily*” сонинд Өмнөд Чангчену 16 мал аж ахуй эрхлэгч тус бүр 100 сая вонг нийлүүлээд Камбожид 474 га газар худалдан авсан тухай өгүүлжээ. Сонинд газрыг худалдаж авсан үнийг тайлбарлахдаа 3.3. ам дөрвөлжин метр буюу 1 пянг газар ойролцоогоор 200 воны үнэтэй байсан гэсэн байна. *(Камбожийн хуулиар гадны иргэдэд газар эзэмшихийг зөвшөөрдөггүй тул хувь нийлүүлсэн мөнгөний ихээхэн хэсэг нь хамтарсан компани байгуулах зэрэг бусад зардалд явсан байх гэж би хувьдаа таамаглаж байгаа юм)*. Солонгосчууд ийнхүү худалдаж авсан газартаа эрдэнэ шиш тарих нь гадаад орноос худалдаж авснаас 20 хувиар хямд тусна гэж тооцож байгаа ажээ. <http://joongangdaily.joins.com/article/view.asp?aid=2912601>

Газрын үнийг тооцвол **474 га газрыг 287сая орчим вон буюу 261 мянган ам доллараар худалдаж авсан байна**. Өөрөөр хэлбэл, **1 га газар 550 орчим ам. доллар** болжээ. Харин анх нийлүүлсэн 16х100 сая вонгоор тооцвол 1 га газар худалдан авахад 3000 гаруй ам. доллар зарцуулсан болж таарч байна. Ямартаа ч Аргентинд газар авч байсан үеийнхтэй харьцуулбал газрын үнэ сүүлийн 40 жилийн дотор нилээдгүй өссөн нь илэрхий.

Баримт 3: 2009 оны 5 сард “The Economist” сэтгүүлд энэ талаар сонирхолтой тоо баримт дурьджээ. АНУ-ын нийслэлд байрладаг Олон Улсын Хүнсний бодлого судлалын хүрээлэнгийн тооцоогоор 2006-2009 оны хооронд буурай хөгжилтэй орнуудын газар нутагт гадныхан санаархах нь нэмэгдэж, улмаар 15-20 сая га тариалангийн газрыг гадныхан өмчлүүлэх талаар гэрээ хэлэлцээр хийгдэж, үйл ажиллагаа явагдсан ажээ. Газрын үнэ ханшийг хамгийн хямдаар бодож үзэхэд эдгээр хэлэлцээрийн нийт дүн 20-30 тэрбум ам. доллар байна гэсэн тооцоо ч гарч. http://www.economist.com/node/13692889?story_id=13692889

Олон Улсын Хүнсний Бодлого Судлалын Хүрээлэнгийн мэдээ баримтад тулгуурлан тооцож үзвэл **1 га газрын хамгийн доод ханшийг 1300 ам. доллараар боджээ**.

Тэгвэл **Монгол улсын хамгийн үржил шимтэй газар тариалангийн нутаг Халх голын сав орчмын 330 мянга 600 га буюу 1 тэрбум пянг талбайтай газар ямар үнэтэй байх вэ???**

Солонгосчууд ямар учраас газар худалдаж авах болов?

Өмнөд Солонгос нийт хүнсний бүтээгдэхүүнийхээ 90 гаруй хувийг гадаадаас зөөдөг мөн газар нутгийнхаа дөнгөж 17 хувь дээр газар тариалан эрхэлдэг тул хоол хүнсний хангамжийн ноцтой асуудалтай улс оронд тооцогддог. Тиймээс ч хүнснийхээ үйлдвэрлэлийг бэхжүүлэх, гадаадад өөрийн хүнс үйлдвэрлэдэг баазтай болохыг эртнээс сонирхож иржээ. 2007-2008 оны хүнсний хямралд өртсөн Өмнөд Солонгос сургамжийг тусган авч, Суданаас 690 мянган га газар худалдаж авсан байна.

http://www.wilsoncenter.org/index.cfm?fuseaction=events.event_summary&event_id=517903

<http://futuredirections.org.au/publications/14-strategic-weekly-analysis/48-strategic-weekly-analysis-18-5-2011.html>

2008 онд Солонгосын Daewoo корпораци Мадагаскараас 1.3 сая га газар буюу тус арлын үржил шимтэй газрын тал хувийг 99 жилийн хугацаатайгаар асар хямдаар түрээслэх гэж сэмхэн оролдсоныг нутгийн ард иргэд эсэргүүцэн боссоноор 100 гаруй хүн амь үрэгдсэн ноцтой тэмцэл өрнөсөн билээ. Улмаар төрийн эргэлт гарч, гадныхантай нууц хуйвалдсан ерөнхийлөгч Марк Раваломананаг огцруулсан юм. Мадагаскарын шинэ ерөнхийлөгч сонгогдмогцоо тус **улсын газар нутгийг түрээслэх, худалдах асуудал нь үндсэн хуулийг зөрчсөн хэрэг** гээд, хэрэвзээ ингэх шаардлага гарвал үндсэн хуулиа өөрчилж, ард түмэнтэйгээ хэлэлцэх болно хэмээн зарлаж, газар түрээслэх гэрээг цуцалсан түүхтэй билээ. <http://news.bbc.co.uk/2/hi/africa/7952628.stm>

<http://www.telegraph.co.uk/news/worldnews/africaandindianocean/madagascar/5006110/Madagascar-president-forced-to-resign.html>

<http://www.telegraph.co.uk/news/worldnews/africaandindianocean/madagascar/5012961/Madagascars-new-leader-cancels-Korean-land-deal.html>

Дэлхий нийтийн чиг хандлага ямар байна?

Эрдэмтэн судлаачдын үзэж буйгаар дэлхийн хүн ам жилд 80 саяар нэмэгдэж буй тул тун удахгүй манай гариг хүн төрөлхтний хүнсний хэрэгцээг хангаж дийлэхгүй болох юм байна. Тухайлбал, 2050 он гэхэд дэлхийн хүн ам 9 тэрбум давах төлөвтэй бөгөөд тэдний дийлэнхи нь хөгжиж буй орнуудад амьдрах юм. Тэр үед хүнсний хэрэгцээ одооныхоос 2 дахин өсөх ба хүнсний үйлдвэрлэл энэ их хэрэгцээг хангаж чадахгүй нь тодорхой болжээ.

Саяхан Олон Улсын Усны Менежментийн Хүрээлэнгээс 2050 он гэхэд дэлхийн ус хомсдож, 7 тэрбум хүнд усны хүрэлцээ тааруу болох төлөвтэйгээс 2 тэрбум гаруй хүн усны гачигдал хомсдолд туйлын хүндээр нэрвэгдэнэ гэж мэдэгдсэн байна. Дээрээс нь үржил шимтэй тариалангийн газрын доройтол (өнөөдөр 25 хувийг нь дахин ашиглах боломжгүй болсон), хоол хүнсэн дэх бичил элементийн хомсдол, байгаль цаг уурын өөрчлөлт гээд олон асуудал давхцах аж.

Түүнчлэн нүүрс төрөгчийн давхар исэл (CO₂), дэлхийн дулаарлын нөлөө, мөн усанд угаагдсан химийн бордоо, үйлдвэрийн бохир ус цутгасны улмаас далайн амьдрал аажмаар мөхөж байна. Саяхан л гэхэд Фукушимагийн АЦС-ын ослын улмаас олон зуун тонн хорт цацрагтай усыг Номхон далайд юүлсэн билээ.



Хүн амын хэт өсөлт, байгаль орчны доройтлын улмаас тариалангийн газар ховордож, нэг хүнд ногдох хэмжээ улам бүр буурч байна. Тухайлбал, Рабобанк хэмээх Дэлхийн хөдөө аж ахуйн санхүүжүүлэгч байгууллагаас 1960 онд нэг хүнд 0.45 га газар ногддог байсан бол 2050 онд гэхэд 0.18 га болтлоо буурна гэсэн тооцоо гаргажээ. Ирээдүйд хүнсний гачигдлаас болж хүнсний бүтээгдэхүүний үнэ огцом өсч, гэмт хэрэг нэмэгдэж, эмх замбараагүй байдал, үймээн бослого гарч, усны хомсдол, өлсгөлөн тохиож, хүн ард асар олноороо дүрвэж, дайн тулаан ч эхэлж болзошгүйг эрдэмтэн судлаачид анхааруулжээ.

<http://farmlandgrab.org/post/view/18516>

<http://www.globalresearch.ca/index.php?context=va&aid=12252>

http://www.nzherald.co.nz/world/news/article.cfm?c_id=2&objectid=10692006<http://www.circleofblue.org/waternews/2009/world/water-scarcity-food-security-concerns-prompt-global-land-grab/>

Дэлхийн улс орнууд бэлтгэлээ хэрхэн хангаж байна вэ?

Саяхан болж өнгөрсөн НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын уулзалтан дээр АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтон дэлхий нийт хүнсний үнийн өсөлтийг зогсоон барьж үл чадах аваас асар их хор уршиг дагуулахыг тэмдэглээд, 2007-2008 оны хүнсний хямралаас ч хавьгүй дор зүйл учирч болохыг сануулжээ. 2008 онд дэлхийн олон оронд хүнсний гачигдал тохиолдож, будааны хамгийн том үйлдвэрлэгчид болох Тайланд, Вьетнам, Энэтхэг улсын экспорт буурснаас будааны үнэ тэнгэрт хадаж, хэдэн арван оронд үймээн самуун дэгдэж байжээ.

<http://www.cbn.com/cbnnews/world/2011/May/Clinton-Warns-of-Impending-Food-Crisis/>

Хүнс экспортлогч орнууд экспортоо хязгаарлах бодлого баримтлах болсноор хүнсээ гаднаас зөөдөг улс орнууд бэлтгэлээ хангаж эхэлсэн байна. Зөвхөн Өмнөд Солонгосоор тогтохгүй, Хятад, Япон, Саудын Араб, Кувейт зэрэг улсууд бусад орнуудын газар нутгаас түрээслэх буюу худалдан авч, дотоодын хоол хүнс, био түлш бэлтгэх баазаа байгуулж эхэлжээ. Олон Улсын Хүнсний Бодлого Судлалын Хүрээлэнгээс зарим нэг улс орнууд 2006-2009 онуудад газар нутгаа хэрхэн өргөтгөсөн тухай мэдээллийг хүснэгтээр үзүүлжээ.



http://www.economist.com/node/13692889?story_id=13692889

<http://www.circleofblue.org/waternews/2009/world/africa/outsourcing-irrigation-farming-discontent/>

“Land grab” гэж юу вэ?



Үүнтэй зэрэгцэн авилгад идэгдсэн засгийн газартай, ядуу даржин улс орнуудын газар нутгийг нь харийнхан урт хугацаагаар түрээслэх, төр засгийн түшмэдүүдтэй хуйвалдаж сэм аргаар худалдаж авахыг хэлдэг “land grab” буюу орчуулбал “газар булаах” гэдэг хэллэг олон улсад бий болжээ. Бусдын газар нутгийг булааж аваад тариа ногоо тарьж, уугуул нутгийнхан нь өлсөж зовж байхад ургацаа хурааж аваад жишим ч үгүй гадагш зөөхийг ёс суртахуунгүй асуудал, тэр байтугай нео-колониаллолын хэлбэр, хөдөө аж ахуйн империализм гэж үзэх явдал цөөнгүй байна. Иймээс ч энэ нийтлэлд иш татсан гадны эх сурвалжуудад **Солонгосчууд Монголын газар нутгаас булаажээ** гэж бичсэн ажээ.

<http://iboninternational.org/resources/pages/EDM/76/72>

<http://www.actnowpng.org/content/ifc-part-new-neo-colonial-land-grab-0>

http://www.koreatimes.co.kr/www/news/biz/2009/12/123_56697.html

Ядуу буурай орнууд харийнханд газар нутгаа алдаж буйг “The Economist” сэтгүүлд дэлгэрэнгүй бичиж бас газрын зураг дээр үзүүлснийг сонирхоно уу.



Эх сурвалж: “The Economist” сэтгүүл, “Outsourcing Third Wave” өгүүлэл, 2009-05-21.

http://www.economist.com/node/13692889?story_id=13692889

Газар нутгаа зарах нь Монголчуудад ашигтай юу?

Олон улсын хэмжээнд авч үзвэл ийнхүү бусдын газар нутгийг булаах нь хүнс тэжээлийн хомсдлыг тууштай шийдвэрлэхгүй, ердөө л түр зуур амиа аргацаасан арга юм байна. Учир нь гадны хөрөнгө оруулагч нар мөнгөө хурдан эргүүлж олохын тулд газар тариалангийн газрыг маш түрэмгий, хайр гамгүй ашигладаг аж. Газар нутгаа наймаалсан улсын хүн ард нь үгүйрэн ядуурч, өлсгөлөнд нэрвэгдэж, байгаль орчин нь сүйрч, газрын хөрс нь химийн бодисонд хорддог түүхтэй.

Харийнхан орон нутгийн ард иргэдийг шинээр өмчилсөн газар нутгаасаа хөөж, шилжин суурьшихыг шаарддаг. Эхэндээ газар нутгаа найр тавин өгсөн эрх мэдэлтнүүд болон худалдан авч буй гадны хөрөнгө оруулагч нар газар нутгаа түрээслэх/наймаалахын ач холбогдлыг дуу нийлүүлэн магтаж, **ажлын байр шинээр бий болгоно, үлгэр жишээ аж ахуй байгуулна, орон нутгийн ард**

иргэдэд тарьж ургуулсан тариа ногооноосоо өгнө гэх авч энэ бүгд нь ард иргэдээс газар нутгийг нь өөрсдийн эрх ашгийг хангахын төлөө булаан авсан үйлдлийн халхавч төдий байдаг аж. <http://farmlandgrab.org/post/view/2522>

<http://www.guardian.co.uk/environment/2008/nov/22/food-biofuels>

<http://www.thenational.ae/business/economy/offshore-farms-for-gulf-food-self-sufficiency-hampered-by-hungry-masses>

Шинжээчдийн бичиж буйгаар энэхүү шинэ колоничлолын гамшигт үр дагавраас болж газар нутгаа алдсан малчид, тариачид зэрэг **эрх мэдэлгүй ядуус хамгийн ихээр хохирдог. Гадны хөрөнгө оруулагч нар орон нутгийн эрх баригчид, төр засгийн эрх мэдэлтнүүдийн мөнгөөр худалдаж авсан байдаг** тул орон нутгийн ард иргэд хамгаалах хүн, хандах газаргүй болж хүчин мөхөсддөг.

Амьжиргааны эх үүсвэрээ алдсан ардууд харийнханд зарцлагдаж, боолын хөдөлмөр эрхлэх эсвэл төрж өссөн нутгаа орхиж явахаас аргагүй байдалд ордог. Английн эрдэмтэн Ама Байни нийтлэлдээ цөхөрсөн тариаланчдын дунд амиа хорлох явдал цөөнгүй гардгийг тэмдэглээд, 1987-2007 онуудад Энэтхэгт явуулсан неолиберал эдийн засгийн шинэчлэлийн улмаас өр зээлд унасан 183 мянган тариачин өөрсдийгөө егүүтгэсэн тухай тоо баримтыг иш татжээ.


<http://farmlandgrab.org/post/view/7627>

2011 онд Дэлхийн Хүнсний Хөтөлбөрөөс эмхэтгэж гаргасан мэдээ, түүнчлэн дэлхийн хүн ам хоол хүнсээр хэрхэн дутагдаж буйг үзүүлсэн “World Hunger Map” гэгч газрын зургаас үзвэл гунигт дүр зураг тодорно. Монголчууд дотоод гадаадын дайн тулаан, олон жилийн ган гачигт нэрвэгдсэн Африкийн арваад орон болон Боливийн ард түмнээс арай дөнгүүр байдалд буй ч Намиби, Гвиней зэргийн Африкийн бусад орныхон, мөн Узбек, Киргизчүүдээс дор, өлөн зэлмүүн амьдардаг аж. Ойр орчны улс орнуудаас Ардчилсан Солонгос л манайхтай ижил үзүүлэлттэй юм байна.

Тооны хэлээр яривал Монголын нийт хүн амын 20-35 хувь нь өлөн зэлмүүн явдаг гэсэн байна. Угтаа бол энэ нь өмнөх жилүүдээс сайжирсан үзүүлэлт боловч (2006 оны байдлаар Монгол улс нь Африкийн хэдэн орон бас Афганистаны хамтаар 5-р бүлэг улс буюу хүн амынх нь 35-асс дээш хувь нь хүнс тэжээлийн дутагдалтай гэсэн ангилалд орж байсан билээ) асар их баялагтай, 2 сая гаруйхан хүн амтай улс орныг өлөн байлгаж чадаж буй нь гайхалтай ховор үзэгдэл бололтой (300 мянга орчим хүн гадаадад амьдарч буй тул хамаарахгүй) .

<http://documents.wfp.org/stellent/groups/public/documents/communications/wfp229328.pdf>

<http://www.geographictravels.com/2008/07/world-hunger-map.html>



Монголын төр засаг юу хийж байна?

Олон улсын шинжээчид эдийн засаг, хүнсний хомсдол нүүрлэж буй өнөө цагт газар нутгийг алтнаас ч илүү үнэтэй асар нандин баялаг гэж нэрлэж байхад Монголын эрх баригчид жишиг аж ахуй байгуулах нэрээр үржил шимтэй газар нутгаасаа гаднын улсуудад худалдах, түрээслэх тал дээр онцгой анхаарч буй бололтой. <http://ipsnews.net/news.asp?idnews=54119>

Гадаадын хэвлэлд хүртэл энэ талаар бичих болжээ. Нэг жишээ гэвэл Энэтхэгийн “India Together” сонинд эрх баригчид хууль тогтоолыг өөрсдийн эрх ашигт нийцүүлэн засч найруулдагийг буруушааж, Аргентин, Монгол, Орос гээд олон улсын төрийн түшмэд газар нутгаа гадныханд зарахаар бэлдэж хуулиа засч өөрчилж байна гэжээ. <http://www.indiatogether.org/2008/nov/dsh-farmland.htm>



2010 оны 4 сард Энэтхэгийн “*Info Change India News*” сонинд мэдээлэхдээ Монгол улсын Ерөнхийлөгч Элбэгдорж Энэтхэг улсад албан ёсны айлчлал хийхдээ “Монголд хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх нь өндөр ач холбогдолтой” гээд Пунжаб мужийн тариачдыг Монголд ирж ажиллахыг онцгойлон урьсан. Харин **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т. Бадамжунай** Энэтхэгийн газар тариаланчид, хөдөө аж ахуйн компаниудад хандаж **Монголд тариалангийн газар төлбөртэй түрээслэхийг санал болгожээ.**

<http://farmlandgrab.org/post/view/11985>



Энэ дашрамд дээрх нийтлэлд Энэтхэгийн тариаланчдад гадныхны тавьсан үнийн саналыг мэдээлснийг бас дурдья. Тухайлбал, Судан улс 1 акр цөл газраа жилийн 0.25 ам.доллараар буюу хөрвүүлбэл, 1 га газраа жилийн 0.62 ам.

доллараар түрээслүүлэх санал тавьсан бол Сенегал улс 1 га газраа жилийн 40 ам. доллараар түрээслүүлэх саналтайгаа мэдэгджээ.

2009 оны 7 сард Солонгосын Хойт Генгсанг (Gyeongsang) мужийн засаг захиргаа Монгол улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай Харилцан ойлголцлын санамж бичиг үзэглэж, Улаанбаатар хотод хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих төв байгуулсан байна. Улмаар тус төв болон *Gaeunram* гэгч Солонгосын хөдөө аж ахуйн компаниар дамжуулан Булган аймгийн нутагт 20 мянган га газрыг Солонгосын тариаланчдад 40 жил ашиглуулахаар тохиролцсон тухай Солонгосын хэвлэлд бичжээ. Зарим эх сурвалжид 52 мянган га газар гэсэн ч байна.

<http://joongangdaily.joins.com/article/view.asp?aid=2912601>

http://www.koreatimes.co.kr/www/news/biz/2009/12/123_56697.html

<http://www.circleofblue.org/waternews/2009/world/water-scarcity-food-security-concerns-prompt-global-land-grab/>

Мөн Хятадууд ч Монголын газрыг түрээсээр ашигладаг тухай мэдээ АНУ-ын хэвлэлд гарчээ. <http://cornandsoybeandigest.com/issues/foreigners-gobble-land-some-claim-it-s-food-security-some-say-it-s-land-grab?page=2>



Дорнодын тал Халхын гол сав нутагт 330 мянга гаруй га газар худалдаж авсан гэж Солонгосчууд зарласнаас гадна Австрали, АНУ, Азийн олон мэдээллийн сувгуудаар мэдээлснийг дээр баримттайгаар гаргаж тавьсан билээ. КОИСА-тай байгуулсан гэрээнд Монгол талаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яамны төлөөлөгчид 2011 оны 3-дугаар сарын 10-нд үзэглэсэн ч Монголын засгийн газар хэвлэлээр гарсан шуугианд тайлбар өгөлгүй түдгэлзэж сууна.

<http://sonin.mn/?p=135863>

Солонгос улстай хийсэн газрын наймаа нь Монгол улсын Үндсэн Хууль, Газрын тухай хуулинд заасан “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”, “Монгол Улсын газар нутаг салшгүй

бүрэн бүтэн, газрын сан нэгдмэл байна” гэсэн заалтуудыг зөрчиж байна. Хэдхэн жилийн өмнө яг ийм явдлаас болж Мадагаскарын ард түмэн босч, авилгач эрх баригчдаа огцруулсан түүхийг өмнө дурьдсан. Монголд ч ийм түүх давтагдаж болзошгүй болоод байна.

Хожмын нэг өдөр харийнхны хялбар олз болохыг нь мэдсэн бол өвөг дээдэс минь Халхын Голын төлөө цусаа урсган дайтаж, амь насаараа хамгаалан авч үлдэх хэрэг байсан гэж үү?

Амарлин

golomt.org

2011-05-25